БАТЛАВ:
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

..............................
С.БАТБОЛД

БАТЛАВ:
"И-ТЕХ" ХХК-НЫ ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРАЛ

..............................
С.НАЦАГДОРЖ

# ОЛОН УЛС, УЛСЫН ЧАНАРТАЙ АВТО ЗАМ, ТҮҮНИЙ ДАГУУХ СУУРИН ГАЗАР, ДЭД БҮТЭЦ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БҮС НУТАГ, ТҮҮХЭН ДУРСГАЛТ ГАЗРУУДЫН МЭДЭЭЛЛИЙГ "GOOGLE MAP" СИСТЕМД БАЙРШУУЛАХ АЖИЛ ГҮЙЦЭТГЭХ ГЭРЭЭ

2024 оны 04 -р сарын 11 -ний өдөр Дугаар 175 Улаанбаатар хот

## НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1. Энэхүү гэрээг нэг талаас **Зам, тээврийн хөгжлийн яам** /Регистрийн дугаар: 5919487/ түүнийг төлөөлж МТХ-ийн дарга Д.Гэрэлням / "Цаашид Захиалагч" гэх/, нөгөө талаас **"И-Тех" ХХК-ний менежер ажилтай Ш.Эрдэнэпүрэв** /цаашид "гүйцэтгэгч" гэх/, хамтад нь "талууд" гэх/ нар Монгол Улсын Иргэний хуулийн 343 дугаар зүйл болон бусад хууль тогтоомжийг удирдлага болгон дараах нөхцөлөөр харилцан тохиролцож энэхүү гэрээг байгуулав.

1.2. Энэхүү гэрээний зорилго нь гүйцэтгэгч нь захиалагчийн баталсан ажлын даалгаврын дагуу зам, тээврийн салбарын бүтээн байгуулалт, олон улс, улсын чанартай авто зам, түүний дагуух байгалийн үзэсгэлэнт болон түүхэн дурсгалт газар, нисэх буудлын байршил зүйн мэдээлэл, стандартын дагуу авсан зураг, мэдээллийг "Google map" системд байршуулж олон улс, улсын чанартай хатуу хучилттай авто замаар зорчигчдыг мэдээллээр хангахад оршино.

## ХОЁР. ГЭРЭЭНИЙ ХУГАЦАА, ТӨЛБӨР ТООЦОО ХИЙХ

2.1 Гэрээний ерөнхий хугацаа 2024 оны 04 сарын 10-ны өдрөөс 2024 оны 10 сарын 01 -ний өдөр хүртэл хугацаатай байна.Үүнд холбогдох байгууллагын Google хаягаас Google-д бүртгүүлж батаалгаажсан эсэхийг нягталж панорама зургаа оруулах боломж бүрдэнэ.

2.2 Гэрээгээр гүйцэтгэх ажлын нийт үнэ 19,800,000 төгрөг /арван есөн сая найман зуун мянган/ бөгөөд гүйцэтгэгчээс ирүүлсэн нэхэмжлэхийн дагуу Захиалагч холбогдох дансанд шилжүүлнэ.

## ГУРАВ. ГҮЙЦЭТГЭГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

3.1 Гүйцэтгэгч нь ажлыг гэрээ хийснээс хойш дөрвөн долоо хоногийн дотор цаг агаарын нөхцөлийг үндэслэн гүйцэтгэнэ.

3.2 Гэрээгээр хүлээсэн ажил, үүргийг мэргэжлийн өндөр түвшинд хийж гүйцэтгэн гэрээнд заасан хугацаанд нь Захиалагчид хүлээлгэн өгөх үүрэгтэй.

3.3 Гүйцэтгэсэн ажлын үр дүнг Захиалагчид хүлээлгэн өгөхөөс өмнө ажлын үр дүнд учирч болох эрсдэлийг дангаар хариуцах үүрэгтэй.

3.4 Гэрээт ажлын чанар болон гүйцэтгэлийн талаар захиалагч талаас тавьсан шаардлагыг биелүүлэх бөгөөд гэрээт ажлыг аливаа алдаа доголдолтой гүйцэтгэсэн тохиолдолд алдаа доголдлыг өөрийн зардлаар тухай бүрт нь арилган дахин гүйцэтгэнэ.

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Төрийн нарийн бичгийн дарга 2024 оны 175 дугаар гэрээ

3.5 Гүйцэтгэсэн ажлын төлбөрийг тухай бүрт нь захиалагч талаас нэхэмжлэх эрхтэй.

3.6 Гүйцэтгэгч тал нь захиалагч талаас гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлэхийг шаардах, үйлчилгээний төлбөрийг энэхүү гэрээгээр заасан хугацаанд нэхэмжлэх эрхтэй.

3.7 Гүйцэтгэгч нь Захиалагч байгууллагын хэрэгцээнд 360 панорама зургуудаа файлаар нь өгнө.

3.8 Гүйцэтгэгч нь орон нутаг, төв суурин газарт системийн админыг захиалагч талтай хамтран томилуулж холбогдох сургалтыг зохион байгуулна.

## ДӨРӨВ. ЗАХИАЛАГЧИЙН ЭРХ, ҮҮРЭГ

4.1 Ажил гүйцэтгэх тохиромжтой хугацааг гүйцэтгэгч талд ажлын 1-2 өдрийн өмнө мэдэгдэнэ.

4.2 Гэрээний дагуух ажил гүйцэтгэсэний төлбөрийг заагдсан хугацаанд төлж барагдуулах үүрэгтэй.

4.3 Захиалагч тал нь гүйцэтгэгч талаас гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэхийг шаардах, ажлын явцтай танилцах, шаардлагатай мэдээллийг авах эрхтэй.

4.4 Ажил гүйцэтгэгч нь гэрээгээр хүлээсэн ажил, үүргээ зөрчиж ноцтой алдаа, дутагдал гаргасан болон хугацаа алдсан тохиолдолд Захиалагч нь энэхүү гэрээг нэг талын санаачлагаар цуцлах ба өөрт учирсан хохирлоо нөхөн төлүүлэх эрхтэй.

4.5 Гүйцэтгэсэн ажлын үр дүн доголдолтой бол ажил гүйцэтгэгчийн зардалаар уг доголдлыг арилгуулах, эсхүл ажлыг шинээр гүйцэтгүүлэхээр шаардах эрхтэй.

## ТАВ. ТАЛУУДЫН ХҮЛЭЭХ ХАРИУЦЛАГА

5.1 Гүйцэтгэгч тал “ажил”-ыг чанарын шаардлага хангасан, өндөр түвшинд хийж гүйцэтгэж акт үйлдэн хүлээлгэж өгнө.

5.2 Захиалагч тал гүйцэтгэсэн “ажил” мэдээ, мэдээллийн өөрчлөлт оруулах шаарлага гарвал гүйцэтгэгч талд мэдэгдэж өөрчлөлтийг хийлгүүлнэ. /Уг байгууллагын хаяг, холбогдох мэдээллийн өөрчлөлт/

5.3 Ажил гүйцэтгэгдэх явцад гүйцэтгэгчийн гүйцэтгэсэн ажилд ямар нэг доголдол илэрвэл гүйцэтгэгч тал доголдлыг өөрийн зардлаар арилгах үүрэг хүлээнэ.

5.4 Доголдол гэдэгт захиалагч талын мэдээллийг захиалагчийн зөвшөөрөлгүйгээр өөрчлөн байрлуулсан, дутуу байрлуулсан, “ажил” захиалагчийн шаардлагад нийцээгүй, хугацаанд нь нэвтрүүлээгүй эсвэл захиалагчийн бэлдэж өгсөнөөс өөр мэдээ, мэдээлэл байрлуулсан зэргийг хамруулан ойлгоно.

5.5 Гүйцэтгэгч тал энэхүү гэрээний 5.4-т заасан доголдлыг гарилгаж ажлыг дахин гүйцэтгэх үүрэг хүлээнэ.

5.6 Захиалагч нь гэрээнд заасан хугацаанд төлбөрөө төлөөгүй тохиолдолд хугацаа хэтрүүлсэн хоног тутамд төлбөл зохих үнийнд үнгийн 0,2 хувьтай тэнцэх хэмжээний алдангийг гүйцэтгэгч талд төлнө.

5.7 Гүйцэтгэгч гэрээгээр хүлээсэн үүргээ биелүүлээгүй тохиолдолд Захиалагч нь нэг талын санаачлагаар гэрээг цуцлах эрхтэй.

## ЗУРГАА. ДАВАГДАШГҮЙ ХҮЧИН ЗҮЙЛС

6.1 Холбогдох хууль тогтоомжинд заасан гэнэтийн давагдашгүй хүчин зүйлсийн улмаас Талуудын аль нэг нь гэрээнд заасан үүргээ биелүүлээгүй буюу *зохих ёсоор* биелүүлээгүй бол нөгөө талдаа ажлын гурав хоногийн дотор бичгээр мэдэгдэх ба энэ тохиолдолд үүрэг гүйцэтгэх хугацаа нь энэхүү нөхцөл байдал үргэлжлэх хугацаагаар хойшлогдоно.

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Төрийн нарийн бичгийн даргын ... гэрээ
2024 125

6.2 Гэнэтийн давагдашгүй хүчин зүйлс бий болсон нь хуанлийн нэг сараас дээш хугацаагаар үргэлжилбэл Талууд асуудлыг харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ.

6.3 Гэнэтийн давагдашгүй хүчин зүйл гэдэгт гал түймэр, газар хөдлөлт, салхи шуурга, аянга цахилгаан, үер усны гамшиг зэрэг байгалийн гамшиг, нийтийг хамарсан үймээн, эсэргүүцлийн хөдөлгөөн, төрийн эрх бүхий байгууллагын шийдвэр, хорио, цээр зэрэг талуудын хүсэл зоригоос үл хамаарах шалтгаануудыг ойлгоно.

## ДОЛОО. МАРГААН ШИЙДВЭРЛЭХ

7.1 Энэхүү гэрээтэй холбогдон гарч болзошгүй бүх санал зөрөлдөөн, маргааныг Талууд харилцан зөвшилцөх замаар шийдвэрлэнэ. Санал зөрөлдөөн, маргааныг зөвшилцөн өөр шийдвэрлэж чадахгүй тохиолдолд харъяалах шатны шүүхээр шийдвэрлүүлнэ.

## НАЙМ. БУСАД ЗҮЙЛ

8.1 Гүйцэтгэгчийн нэхэмжлэл, Захиалгын хуудас, ажил хүлээлцсэн акт зэрэг нь гэрээний хавсралт болох бөгөөд эдгээр нь гэрээний салшгүйх эсэг болно.

8.2 Талууд харилцан тохиролцсоны үндсэн дээр гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулах ба нэмэлт өөрчлөлт болон түүнийг мөрдөх хугацааг тохиролцсон тухай баримт, албан бичиг үйлдэж, талуудын эрх бүхий албан тушаалтнууд гарын үсэг зурснаар хүчин төгөлдөр болох бөгөөд уг баримт бичгийг энэхүү гэрээний бүрэлдэхүүн хэсэг гэж үзнэ.

8.3 Энэ гэрээнд заасан хугацааг ажлын хоногоор бодох бөгөөд Талуудын удирдлага, гүйцэтгэх захирал, үүсгэн байгуулагчид, өмчлөгчид нь өөрчлөгдсөнөөс үл хамааран энэхүү гэрээ нь үйлчлэх хугацааны туршдаа хүчин төгөлдөр байна.

8.4 Энэхүү гэрээг монгол хэл дээр 2 хувь үйлдэж, тал тус бүр нэг хувийг хадгалах бөгөөд хувь тус бүр хууль зүйн адил хүчинтэй байна.

8.5 Талууд гэрээнд гарын үсэг зурж баталгаажуулсан өдрөөс энэхүү гэрээ хүчин төгөлдөр мөрдөгдөнө.

## ЕС. ГЭРЭЭ БАЙГУУЛСАН

**Захиалагчийг төлөөлж:**
**ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ-ыг ТӨЛӨӨЛЖ:**

Бодлого, төлөвлөлтийн газрын Мэдээллийн технологийн хэлтсийн дарга
Д.ГЭРЭЛНЯМ

Санхүү хөрөнгө оруулалтын хэлтсийн дарга
Н.ЦЭВЭЛМАА

Төрийн захиргааны удирдлагын газрын Хуулийн хэлтсийн шинжээч
Д.ОЮУНСҮРЭН

Мэдээллийн технологийн хэлтсийн мэргэжилтэн
Б.ГҮНХИЧЭЭНГҮЙ

**Гүйцэтгэгчийг төлөөлж:**
И-Тех ХХК-ны менежер

.......................................................
**Ш.Эрдэнэпүрэв**

**Албан ёсны хаяг:**
Итех ХХК
**Гар утас:**91143601
**И-мэйл хаяг:**
eerepure@gmail.com
Компанийн улсын бүртгэлийн дугаар: 9011276141
Регистрийн дугаар: 2780186

МОНГОЛ УЛСЫН
ЗАМ ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМ
ЭХ ХУВЬ
Сайд Төрийн нарийн бичгийн даргын ... оны ... дугаар гэрээ

MINISTRY OF ROAD
AND TRANSPORT DEVELOPMENT
OF MONGOLIA

Government building 13, Chinggis Avenue 11,
Sukhbaatar district, Ulaanbaatar 14251, MONGOLIA
Tel: (976-51) 26 71 68, Fax: (976-11) 31 23 15,
E-mail: info@mrtd.gov.mn, http://www.mrtd.gov.mn

Date 2024 apr 17
Ref. 03/92

MR. AMIT MORYA, PROGRAMME
MANAGER, GOOGLE LLC

Dear Sir,

The Ministry of Road and Transportation Development of Mongolia is collaborating with Mr. Natsagdorj, Director of ETECH LLC, on a project aimed at capturing 360-degree photos of road checkpoints, signage, tourism attractions, historical monuments, museums, local businesses, hotels, restaurants, hospitals, pharmacies, car repair centers, and other service facilities across the KHOVD and BAYANULGII provinces in western Mongolia, covering approximately 5,000 kilometers.

In recent years, Mongolia has emerged as one of the most appealing destinations for international travelers. However, comprehensive information for tourists is still unknown across the country. Therefore, we are collecting and registering all relevant details for the western provinces of Mongolia on Google Maps, a widely recognized and user-friendly platform globally.

We kindly request your approval for the utilization of Google equipment in support of this aforementioned project.

Thank you for your consideration.

Sincerely,

MR. BATBOLD, S
STATE SECRETARY,
MINISTRY OF ROAD AND TRANSPORT
DEVELOPMENT, MONGOLIA

080000162

GOOGLE MAP МЭДЭЭЛЭЛ БАЙРШУУЛАХ АЖИЛТАН АЛБАН ХААГЧИЙН МЭДЭЭЛЭЛ

| № | Овог | Нэр | Харьяалагдах аймаг,сум | Байгууллага | Албан тушаал | Утас | И-Мэйл |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Очирбал | Сэлэнгэсайхан | Улаанбаатар | Автотээврийн үндэсний төв | ЗТХэлтсийн мэргэжилтэн | 88036708 | ochirbalselengesaihan@gmail.com |
| 2 | Хоовон | Золжаргал | Говь-Алтай аймгийн Есөнбулаг сум | ГАА-н Автотээврийн төв | Тээвэр зохицуулагч | 99018870 | Zoljargal.kh8668@gmail.com |
| 3 | Түмэндэмбэрэл | Батцэцэг | Булган аймаг | Булган аймгийн Автотээврийн төв | Тээвэр зохицуулагч | 99836682 | t.baagii0080@gmail.com |
| 4 | Тилеу | Сапарбек | Баян-Өлгий аймаг | Баян-Өлгий аймгийн Автотээврийн төв | АТХМ | 88061315 | sankasaparbek@gmail.com |
| 5 | Соронзонболд | Өнөболд | Төв аймаг | Төв аймгийн Автотээврийн төв | АТХМ | 99305998 | s.unubold11@gmail.com |
| 6 | Эрдэнэбат | Нямдорж | Хөвсгөл аймаг | Хөвсгөл аймгийн Автотээврийн төв | Тээвэр зохицуулагч | 99906622 | |
| 7 | Цэрэнбат | Хандсүрэн | Өвөрхангай | Өвөрхангай аймгийн Автотээврийн төв | Тээвэр зохицуулагч | 89626161 | tkhandsuren46@gmail.com |
| 8 | Баянзул | Батхуяг | Баянхонгор аймаг, Баянхонгор сум | Автотээврийн төв | Тээвэр зохицуулагч | 88011339 | Batkhuyag01140104@gmail.com |
| 10 | Пүрэвдорж | Батбаяр | Ховд аймаг | Ховд аймгийн Автотээврийн төв | АТХМ | 99040766 | Baavar992@gmail.com |
| 11 | Баатаржав | Баялаг-Эрдэнэ | Увс аймаг Улаангом сум | Увс аймгийн Автотээврийн төв | Тээвэр зохицуулагч | 90113021 | Bayalagb10@gmail.com |
| 12 | Намсрай | Цэрэндулам | Завхан аймаг, Улиастай сум | Завхан Автотээврийн төв | Ахлах нягтлан бодогч | 99969844 | Mtserendulam874@gmail.com |
| 13 | Долгор | Бат-Эрдэнэ | Архангай аймаг, Эрдэнэбулган сум | Архангай Автотээврийн төв | АТХУБ | 99643871 | bakibaagii01@gmail.com |
| 14 | Ганзориг | Сарантуяа | Хэнтий аймаг | Хэнтий аймгийн Автотээврийн төв | Тээвэр зохицуулагч | 88057017 | |

СИСТЕМД МЭДЭЭЛЭЛ ОРУУЛАХ АЖЛЫГ ХАРИУЦАХ АЛБАН ХААГЧДЫН МЭДЭЭЛЭЛ

| № | Овог | Нэр | Харьяалагдах аймаг, сум | Байгууллага | Албан тушаал | Утас | И-мэйл |
|---|---|---|---|---|---|---|---|
| 1 | Аюур | Бямбабаяр | Ховд аймаг | Ховд АЗЗА ТӨХК | Инженер | 95231137 | Byambuushayur7@gmail.com |
| 2 | Авилайхан | Нурдана | Баян-Өлгий аймаг | Жол ХХК | Инженер | 99920984 | EERKAA_26@yahoo.com |
| 3 | Цэрэндорж | Бадамсамбуу | Баянхонгор аймаг | Их богд зам ХХК | Инженер | 99444494 | Badka9269@gmail.com |
| 4 | Алтаншагай | Эрдэнэхишиг | Говь-Алтай аймаг | Говь-Алтай АЗЗА ТӨХК | Инженер | 99609777 | a.eegii9777@gmail.com |
| 5 | Цогбадрах | Онолжаргал | Булган аймаг Дашинчилэн сум | Булган аймаг Хөвчийн зам ХХК | ня-бо | 91110271 | Khuvchiinzam@gmail.com |
| 6 | Мөнх-Найрамдал | Мөнх-Эрдэм | Булган аймаг Булган сум | Булган АЗЗА ТӨХК | Ерөнхий инженер | 88053241 | Monherdemerdmee@gmail.com |
| 7 | Төмөр | Мөнх-Баатар | Хөвсгөл аймаг | Хөвсгөл АЗЗА ТӨХК | Ерөнхий инженер | 99055314 | mnhbaatartmr@gmail.com |
| 8 | Бибиш | Болдбаатар | Завхан аймаг | Завхан АЗЗА ТӨХК | Ерөнхий инженер | 96024024 | B.Boldoo0926@gmail.com |
| 9 | Пүрэмсамбуу | Ганзориг | Увс аймаг | Увс АЗЗА ТӨХК | Ерөнхий инженер | 88178865 | Ganzo_0990@yahoo.com |
| 10 | Гантулга | Мөнхэрдэнэ | Төв аймаг | ТөвАЗЗА ТӨХК | Механик инженер | 99053772 | muujig3772@gmail.com |
| 11 | Авирмэд | Арсланбаатар | Архангай аймаг | Архангайгай АЗЗА ТӨХК | Ерөнхий инженер | 88071586 | Arslanbaatar940@gmail.com |
| 12 | Баатархүү | Энхтөр | Архангай аймаг | Саруул Харгуй ХХК | Ерөнхий инженер | 88007155 | Enkhturb19@gmail.com |
| 13 | Галбадрах | Төмөрбаатар | Хэнтий аймаг | Харгуй ТӨХК | Ерөнхий инженер | 88888492 | Tumurbaatar8492@gmail.com |
| 14 | Батжаргал | Батбаяр | Өвөрхангай аймаг | Өвөрхангай АЗЗА ТӨХК | Ерөнхий инженер | 88036234 | B.Batbayar7999@gmail.com |

БОЛОВСРУУЛСАН:

ЗТХТ-ТӨҮГ-ЫН АЗАХ

БНХХИ Д.ОТГОНБАЯР

БАТЛАВ:

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН ЯАМНЫ ТӨРИЙН НАРИЙН БИЧГИЙН ДАРГА

С.БАТБОЛД

# ОЛОН УЛС, УЛСЫН ЧАНАРТАЙ АВТО ЗАМ, ТҮҮНИЙ ДАГУУХ СУУРИН ГАЗАР, ДЭД БҮТЭЦ, ҮЙЛЧИЛГЭЭНИЙ БАЙГУУЛАМЖ, АЯЛАЛ ЖУУЛЧЛАЛЫН БҮС НУТАГ, ТҮҮХЭН ДУРСГАЛТ ГАЗРУУДЫН БАЙРШЛЫН МЭДЭЭЛЛИЙГ "GOOGLE MAP" СИСТЕМД БАЙРШУУЛАХ АЖЛЫН ДААЛГАВАР

2024 оны 03 дугаар сарын 27-ны өдөр

Дугаар 07

Улаанбаатар хот

| | | |
|---|---|---|
| 1. | Төсөл хэрэгжүүлэх үндэслэл: | Монгол Улсын Засгийн газрын 2020 оны 203 дугаар тогтоолоор баталсан "Монгол улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө"-ний<br>- 3.4.8. *"Цахим Монгол" арга хэмжээний хүрээнд аялал жуулчлалын салбарт технологийн дэвшил нэвтрүүлж, гадаад сурталчилгааг өргөжүүлнэ.*<br>- *3.6. Эдийн засгийн өсөлтийг хангахуйц, тээврийн ухаалаг системд суурилсан үндэсний тээвэр, логистикийн сүлжээг байгуулна.*<br>Улсын Их Хурлын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан "Алсын хараа-2050" Монгол Улсын Урт хугацааны хөгжлийн бодлого: Зорилт 8.1:<br>- *Бүс нутгийн эдийн засгийн интеграцад дэд бүтцийн нэгдсэн сүлжээгээр бүрэн холбогдож, эдийн засгийн эрчимтэй өсөлтийг хангах суурь нөхцөлийг бүрдүүлнэ.*<br>- *Хэрэглэгч бүрд хүрсэн орчин үеийн ухаалаг тээвэр логистикийн сүлжээг нэвтрүүлсэн байна.* |
| 2. | Төслийн зорилго: | Тээврийн ухаалаг системд тулгуурлан иргэдийн аюулгүй, ая тухтай зорчих нөхцөлийг бүрдүүлэх замаар тээврийн үйлчилгээг хүртээмжтэй хүргэх. |
| 3. | Төслийг захиалагч байгууллага: | Зам, тээврийн хөгжлийн яам, "Автотээврийн үндэсний төв" ТӨҮГ, "Зам тээврийн хөгжлийн төв" ТӨҮГ, "Улаанбаатар төмөр зам" ХНН |
| 4. | Төслийг хэрэгжүүлэгч: | "Google map" системд зураглал оруулах эрх бүхий хувь хүн, эсвэл хуулийн этгээд. |
| 5. | Төслийг хэрэгжүүлэх хугацаа: | 5.1 2024.05.01-2024.06.30 зураг авалт хийх |
| | | 5.2 2024.06.30-2024.08.31 системд оруулах |

| | | |
|---|---|---|
| 6. | Тавигдах шаардлага: | - Хэрэгжүүлэх арга хэмжээ нь олон улсын болон Монгол Улсын хууль тогтоомж, стандарын шаардлагыг хангасан байна;<br>- “Google map” системийн шаардлагад нийцсэн байх;<br>- Ашиглахад хялбар байх;<br>- Мэдээлэл үнэн зөв, бодитой байх;<br>- Нэмэлт өөрчлөлт хийх боломжтой байх;<br>- Гадаад, дотоодын зорчигч, аялагчийг орон зайн мэдээллээр хангах.<br>- Мэдээлэл Монгол, Англи хэл дээр байна. |
| 7. | Төслийн хүрээнд хийгдэх ажлууд: | Олон улс, улсын чанартай авто зам, түүний дагуу дараах байгууламжуудын зураг, байршил зүйн мэдээлэлийг “Google map” системд байршуулна:<br>- *байгалийн үзэсгэлэнт болон түүхэн дурсгалт газар;*<br>- *зам дагуух амрах цэг, үйлчилгээний байгууламж;*<br>- *төв суурин газрууд дахь зочид буудал, худалдааны төв, зоогийн газар, эмнэлэг болон үйлчилгээний бусад байгууллага;*<br>- *авто замын төлбөр авах цэг;*<br>- *шатахуун түгээх станц, цахилгаан тээврийн хэрэгсэл цэнэглэх станц;*<br>- *авто үйлчилгээний байгууллага;*<br>- *автотээвэр, төмөр зам, иргэний нисэхийн зорчигч үйлчилгээний төвүүд;*<br>Хамрах нутаг дэвсгэр:<br>- *Төв, Булган, Хөвсгөл, Өвөрхангай, Баянхонгор, Говь-Алтай, Ховд, Баян-Өлгий, Увс, Завхан, Архангай, Хэнтий аймаг*<br>Хамрах чиглэл:<br>- *Олон улс, улсын чанартай А0301, А07, А0601, А0602, А0603, А18, А0305, А0304 чиглэлийн дугаартай авто замууд*<br>Хамрах хүрээ:<br>- *Дээрх замуудын дагуу 100 км-ын радиус доторх орон зайд байрлах дээрх мэдээллийг цуглуулж байршуулна.*<br>Бусад ажилууд:<br>- Зорчигч, аялагчид үзэхэд энгийн, ойлгомжтой байхаар үйлчилгээний байгууламжийн нэр, хаяг, байршлыг үнэн зөв тодорхойлж, бүтээгдэхүүний танилцуулга, үнэ, тайлбарыг объектийн зургийн хамт “Google map” системд байршуулна; |

| | | |
|---|---|---|
| | | - "Google map" системд байршуулсан мэдээллийг өргөжүүлэх, баяжуулах талаар зохих мэргэжилтэнүүдэд сургалт хийнэ;<br>- Тухай төсөлд хамрагдсан аймаг бүрт тус системд оруулсан мэдээллийн үнэн зөв, бодит байдалд хяналт тавих, засч залруулах үүрэг бүхий албан тушаалтануудыг сурган, томилох. |
| 8. | Захиалагчийн зүгээс үзүүлэх дэмжлэг: | Байгууллага, хувь хүн, нууцлалтай холбоотойгоос бусад мэдээллээр хангана. |
| 9. | Төслийн үр дүн: | Ажлын даалгаврын 8-д заасан авто замын дагуу, 9-д заасан шаардлагыг хангасан "Google map" систем дээрх мэдээллээр зорчигч, аялагчийг хангах боломжийг бүрдүүлнэ. |
| 10. | Төсөлд шаардагдах хөрөнгийн хэмжээ: | Харилцан тохиролцоно. |
| 11. | Тайлан: | Захиалагчийн өгсөн ажлын даалгаврын хүрээнд гүйцэтгэсэн ажлын тайланг хүлээлгэн өгнө. |